

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/70/НА-СТА-ТХН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: П.Чанцалдулам  
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn  
Аудитор: Г.Тэлүүн  
Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн  
Захирал: Ц.Жигдэн  
Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	8
3.1 Төслийн үйл ажиллагаа .....	8
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	9
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БСҮХАА	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны ажлын алба
ГХНЦ	Гадаад худалдааны цахим нэг цонх
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТХМХ	Төлөвлөлт хяналт мониторингийн хүрээ
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.10 № 06/1055  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн нийт санхүүжилт нь 29.0 сая ам.доллар бөгөөд тайлант оны эцэст нийт зээлийн ашиглалт өссөн дүнгээр 19.9 сая ам.доллар буюу 73.9 хувьтай байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Алтанбулаг хилийн боомтын барилга байгууламж, дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг "Монкон констракшн" ХХК гүйцэтгэж, 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн Улсын комиссын актаар ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Компани 2024 онд зураг төслийн өөрчлөлтөөс шалтгаалан гэрээний үнийн дүнд 12,790,435.7 мянган

төгрөгийн төлбөрийг нэхэмжилсэн боловч 2 тал харилцан тохиролцож чадаагүй тул компани Монголын олон улсын арбитра нэхэмжлэх гаргасан байна. Уг нэхэмжлэхийн хариуцагч Сангийн Яам нь Монголын олон улсын арбитра шийдвэрээр 7,544,595.6 мянган төгрөгийг “Монкон констракшн” ХХК-д төлөхөөр болсон нь нэмэлт үргүй зардал гарах эрсдэл үүссэн байна.

Төслийн үйл ажиллагааг 2016-2022 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй боловч хэрэгжилтийн явцад төслийн үйл ажиллагааны хугацааг 3 удаа сунгаж, 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хаахаар товлосон нь гадаад зээлийн төлбөрт төлөх хүүгийн зардлыг нэмэгдүүлж, төсвөөс үр ашиггүй зардал гарах нөхцөл бүрдсэн байна.

### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	БАЛАНСЫН ЗҮЙЛ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,265,581,806.90</b>	<b>1,268,472,986.31</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>3,808,102,519.54</b>	<b>1,268,472,986.31</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>3,808,102,519.54</b>	<b>1,268,472,986.31</b>
31210	Төрийн сангийн харилцах/төгрөг/	53,242,929.37	53,242,929.37
31221	Төрийн сангийн харилцах/валют/	3,754,859,590.18	1,215,230,056.95
<b>360</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>33,457,479,287.36</b>	-
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	33,457,479,287.36	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>61,711,896.37</b>	<b>36,741,363,575.28</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>61,711,896.37</b>	<b>36,741,363,575.28</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>61,711,896.37</b>	<b>40,428,786.25</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	192,000,000.00	192,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(136,300,000.00)	(155,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	40,761,692.00	40,761,692.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,761,692.00)	(40,761,692.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,831,100.01	20,831,100.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,819,203.64)	(16,902,313.76)
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	3,400,000.00	3,400,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,400,000.00)	(3,400,000.00)
<b>39400</b>	<b>Бусад эргэлтийн бус хөрөнгө</b>	-	<b>36,700,934,789.03</b>
39405	Дуусаагүй барилга, байгууламж	-	36,700,934,789.03
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>37,327,293,703.27</b>	<b>38,009,836,561.59</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>12,266,050.00</b>	<b>12,266,050.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,266,050.00</b>	<b>12,266,050.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>12,266,050.00</b>	<b>12,266,050.00</b>
4136	Бусад өглөг	12,266,050.00	12,266,050.00
41361	Байгууллагад төлөх өглөг	12,266,050.00	12,266,050.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,315,027,653.27</b>	<b>37,997,570,511.59</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>37,315,027,653.27</b>	<b>37,997,570,511.59</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>37,315,027,653.27</b>	<b>37,997,570,511.59</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	33,467,268,944.88	37,315,027,653.27
51220	Тайлант үеийн үр дүн	3,847,758,708.39	682,542,858.32
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>37,327,293,703.27</b>	<b>38,009,836,561.59</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,162,230,540.41</b>	<b>3,138,237,441.05</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,162,230,540.41</b>	<b>3,138,237,441.05</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,162,230,540.41</b>	<b>3,138,237,441.05</b>
<b>120004</b>	<b>Төсөвт байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,162,230,540.41</b>	<b>3,138,237,441.05</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,800,681,117.92	2,527,991,860.94
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	361,549,422.49	-
120009	Бусад орлого	-	610,245,580.11
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>314,396,621.62</b>	<b>2,618,705,360.57</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>21,288,621.62</b>	<b>21,283,110.12</b>

**Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>21,288,621.62</b>	<b>21,283,110.12</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,511.50</b>	<b>-</b>
210402	Тээвэр, шатахууны зардал	5,511.50	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	21,283,110.12	21,283,110.12
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>293,108,000.00</b>	<b>2,597,422,250.45</b>
<b>2200</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	<b>293,108,000.00</b>	<b>2,597,422,250.45</b>
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал	293,108,000.00	2,597,422,250.45
<b>2108</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>	<b>3,847,833,918.79</b>	<b>519,532,080.48</b>
<b>2109</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>54,299,286.56</b>	<b>182,879,113.20</b>
210902	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	54,299,286.56	182,879,113.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>54,374,496.96</b>	<b>19,868,335.36</b>
4	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	54,374,496.96	19,868,335.36
<b>145001</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(75,210.40)</b>	<b>163,010,777.84</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>3,847,758,708.39</b>	<b>682,542,858.32</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,800,681,117.92</b>	<b>2,527,991,860.94</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,800,681,117.92</b>	<b>2,527,991,860.94</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,800,681,117.92</b>	<b>2,527,991,860.94</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,800,681,117.92	2,527,991,860.94
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,800,681,117.92	2,527,991,860.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>3,800,681,117.92</b>	<b>2,527,991,860.94</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,405,816,425.59</b>	<b>5,230,632,172.01</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,405,816,425.59</b>	<b>5,230,632,172.01</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,405,816,425.59</b>	<b>5,230,632,172.01</b>
220001	Барилга байгууламж	4,528,150,943.31	3,259,920,172.01
222001	Тоног төхөөрөмж	877,665,482.28	1,970,712,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(5,405,816,425.59)</b>	<b>(5,230,632,172.01)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>14</b>	<b>Бусад эх үүсвэр</b>	<b>54,299,286.56</b>	<b>182,879,113.20</b>
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	54,299,286.56	182,879,113.20
<b>25</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	<b>54,374,496.96</b>	<b>19,868,335.36</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	54,374,496.96	19,868,335.36
<b>8</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(75,210.40)</b>	<b>163,010,777.84</b>
<b>9</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(1,605,210,518.07)</b>	<b>(2,539,629,533.23)</b>
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,413,313,037.61	3,808,102,519.54
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,808,102,519.54	1,268,472,986.31

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2023 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>33,467,268,944.88</b>	<b>33,467,268,944.88</b>
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
9	Тайлант үеийн үр дүн	3,847,758,708.39	3,847,758,708.39
10	<b>2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>37,315,027,653.27</b>	<b>37,315,027,653.27</b>
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
19	Тайлант үеийн үр дүн	682,542,858.32	682,542,858.32
20	<b>2025 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл</b>	<b>37,997,570,511.59</b>	<b>37,997,570,511.59</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
3	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,231,000,000.00</b>	<b>5,230,632,172.01</b>	<b>(367,827.99)</b>	<b>99.0</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,231,000,000.00</b>	<b>5,230,632,172.01</b>	<b>(367,827.99)</b>	<b>99.0</b>
220001	Барилга байгууламж	3,260,000,000.00	3,259,920,172.01	(79,827.99)	99.0
222001	Тоног төхөөрөмж	1,971,000,000.00	1,970,712,000.00	(288,000.00)	99.0
8	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-5,231,000,000.00</b>	<b>-5,230,632,172.01</b>	<b>(367,827.99)</b>	<b>99.0</b>
9	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,231,000,000.00</b>	<b>5,230,632,172.01</b>	<b>(367,827.99)</b>	<b>99.0</b>
72	<b>Засгийн газрын зээл</b>	<b>5,231,000,000.00</b>	<b>2,527,991,860.94</b>	<b>(2,703,008,139.06)</b>	<b>48.0</b>
722	Гадаад	5,231,000,000.00	2,527,991,860.94	(2,703,008,139.06)	48.0
7221	Төслийн зээл	5,231,000,000.00	2,527,991,860.94	(2,703,008,139.06)	48.0
322101	Шинээр авах	5,231,000,000.00	2,527,991,860.94	(2,703,008,139.06)	48.0
25	<b>Төсвийн гүйцэтгэлийн тохируулга</b>	-	<b>163,010,777.84</b>	<b>(163,010,777.84)</b>	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,808,102,519.54	(3,808,102,519.54)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,268,472,986.31	(1,268,472,986.31)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
7	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
7.1	АЖИЛЛАГСДЫН ТОО	11	7	4	64.0
7.1	Гүйцэтгэх ажилтан	11	7	4	64.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Төслийн үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн Газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2016 оны 07 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн гэрээний дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийг 2016-2022 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн боловч хэрэгжилтийн явцад төслийн үйл ажиллагааны хугацааг 3 удаа сунгаж, 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хаахаар товлосон байна.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь хилийн үйлчилгээг сайжруулах замаар гадаад худалдааг илүү шуурхай, боловсронгуй болгох, бараа эргэлт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэхэд зарцуулж буй зардал, цаг хугацааг бууруулах зорилготой байна.

Төслийн хүрэх үр дүн:

1. Алтанбулаг боомтын барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх, 1.7 км хатуу хучилттай авто зам барих, Сүхбаатар боомтод хилийн хяналтын байгууллагуудын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барих, Алтанбулаг, Бичигт, Замын-Үүд боомтуудын гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг шинэчлэх;
2. Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /KANC/-ийг шинэчлэх, сүлжээний дэд бүтэц, тоног төхөөрөмжийг өргөтгөх, шинэчлэх;
3. Монгол улсад Гадаад худалдааны цахим нэг цонхны үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахад оршиж байна.

#### 3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Журмын 1.2-т “Журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Иргэний хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно” гэж заасны дагуу үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг байна.

Тайлант хугацаанд төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг дараах хууль, тогтоомж бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам";
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн 174 тоот “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам” зэрэг болно.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөтэй гэж үнэллээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг Гадаад зээл, тусламжийн бүртгэл, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрдөж байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 682,542.8 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,808,102.5	1,268,472.9	(2,539,629.6)
Бусад эргэлтийн хөрөнгө	33,457,479.3	-	(33,457,479.3)
Биет хөрөнгө	61,711.9	40,428.8	(21,283.1)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	36,700,934.8	36,700,934.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>37,327,293.7</b>	<b>38,009,836.5</b>	<b>682,542.8</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>12,266.0</b>	<b>12,266.0</b>	<b>-</b>
Богино хугацаат өр төлбөр	12,266.0	12,266.0	-
Засгийн газрын хувь оролцоо	37,315,027.7	37,997,570.5	682,542.8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>37,327,293.7</b>	<b>38,009,836.5</b>	<b>682,542.8</b>

Дээрх үзүүлэлтээс харахад дараах данстуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Тухайлбал,

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

-Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 2,539,629.6 мянган төгрөгөөр буурсан нь Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс нийт 2,527,991.8 мянган төгрөгийн санхүүжилт орж, хөрөнгийн зардалд 5,230,632.2 мянган төгрөгийг зарцуулж, 19,868.3 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний гарзыг, 182,879.1 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний олзыг тус тус хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

-Бусад эргэлтийн хөрөнгийн 33,457,479.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй дансанд тайлант онд Алтанбулаг боомтын барилга байгууламж, замыг өргөтгөх ажлын гүйцэтгэлд 3,144,456.7 мянган төгрөг, Бичигт боомтын барилгын техникийн зураг гаргах зөвлөх үйлчилгээнд 441,322.8 мянган төгрөг, Алтанбулаг боомтын ухаалаг гарцын төхөөрөмж суурилуулахад 330,000.0 мянган төгрөг, нийт 3,915,779.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, ГЕГ-ын даргын 2025 оны А/32 тоот тушаалаар ГЕГ-ын дэргэдэх Аж ахуйн үйлчилгээний албанд 668,358.5 мянган төгрөгийн Кайс программ ашиглалтын лиценз, Сэлэнгэ аймгийн Гаалийн газарт 3,965.5 мянган төгрөгийн ажлын ширээний нэмэлт хаалтыг тус тус шилжүүлэн өгч, боомтуудад баригдаж буй барилга байгууламж, замын ажлын гүйцэтгэлийн 36,700,934.8 мянган төгрөгийг хуримтлуулан бүртгэж, дуусаагүй барилга, байгууламжийн дансанд шилжүүлэн бүртгэснээр тус данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

- Биет хөрөнгийн үлдэгдэл 40,428.8 мянган төгрөг болж 21,283.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 682,542.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл нь 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжаас 5,231,000.0 мянган төгрөгийг бүрдүүлж, барилга байгууламжийг сайжруулан шинэчлэхэд 3,260,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 1,971,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахаар батлуулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээс олгосон 2,527,991.9 мянган төгрөгийн санхүүжилт болон оны эхний үлдэгдэл 3,808,102.5 мянган төгрөгөөс нийт хөрөнгийн зардалд 5,230,632.2 мянган төгрөг зарцуулж, гүйцэтгэл 99.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт /хувь/
70207	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	5,231,000.0	5,230,632.2	367.8	99.0
80918	Хөрөнгийн зардал	5,231,000.0	5,230,632.2	367.8	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл (МОН-3387) нь 2017 онд баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжих хугацааны 4 бүрэлдэхүүний хүрээнд нийт 66 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн хүрээнд 2019 онд батлагдсан “Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах гарын авлага”-ийн Төлөвлөлт, хяналт мониторингийн хүрээ (ТХМХ)-д тусгаснаар үндсэн төсөл болон нэмэлт санхүүжилтийн хэсгийн зорилт, бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэсэн тул төслийн хэрэгжилтийн тайланг 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нэгтгэн гаргасан байна.

Бүрэлдэхүүн 1: Хилийн боомтуудын барилга байгууламжуудыг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах хүрээнд: Алтанбулаг, Бичигт, Боршоо боомтын барилгын ажлын 7 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулснаас 2025 оны жилийн эцсээр 5 гүйцэтгэгч барилгын ажлыг дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгч, гүйцэтгэл 77.9 хувьтай байна. Төсөлд хамтрагдсан хилийн боомтууд дээр шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан гүйцэтгэл -90.5 хувьтай байна.

Бүрэлдэхүүн 2: Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /КАИС/-ийг сайжруулах, сүлжээний дэд бүтцийг өргөтгөх, тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд: КАИС системийн тоног төхөөрөмжийг боомтуудад 2 үе шаттайгаар шинэчлэн сайжруулсан байна. Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний [www.gaali.mn](http://www.gaali.mn) систем, гэрээ бүртгэлийн нэгдсэн систем, экспорт, импортын мэдэгдэл, гэрчилгээний цахим систем, тусгай зөвшөөрлийн цахим систем зэрэг нийт 30 гаруй үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж цахимаар авах боломжтой болж гүйцэтгэл -100.0 хувьтай байна.

Бүрэлдэхүүн 3: Цахим нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд: ГХЦНЦ-ны системийг нэвтрүүлэх ажлын даалгаврыг менежментийн зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулж хүлээлгэн өгсөн. ГХЦНЦ-ын техникийн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиглэл бүхий хувь зөвлөх үйлчилгээтэй гэрээ байгуулж, ажлын даалгаврыг шинэчилж, Үнэлгээний хороонд танилцуулж, хэлэлцүүлэхэд бэлэн болгосон бөгөөд гүйцэтгэл -55.0 хувьтай байна.

Бүрэлдэхүүн 4: Хилийн холбогдох байгууллагуудын чадавхыг сайжруулах ажлын хүрээнд: Хилийн хяналтын байгууллагууд буюу Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх, дэмжих зорилгоор 2022 оноос үе шаттайгаар нийт 250 ажилтнуудыг сургалтад хамруулж, 53 сургагч багшийг бэлтгэжээ. Мөн сургагч багш нарыг албажуулсан агентлагийн дарга нарын тушаалуудыг гаргасан байна. Хилийн хяналтын байгууллагуудын албан хаагчдад зориулсан сургалтын жишиг хөтөлбөр бүхий гарын авлагыг 10 сэдвийн хүрээнд боловсруулж, гүйцэтгэл 99.0 хувьтай байна.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант онд төлөвлөж, гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн 2025 оны арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Д/д	Бүрэлдэхүүн хэсгийн нэр	Бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд болон 2025 онд гүйцэтгэх ажлын тоо	Хэрэгжилтийн хувь
1	1.Боомтын барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэлийн барилга угсралтын ажлыг дуусгаж, улсын комисст хүлээлгэн өгөх; 2.Барилга угсралтын ажлын явцад хяналт хийх зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн хяналт тавих.	Нийт – 51 2025 онд – 2	99.0
2	1.Бичигт, Боршоо хилийн боомтын барилга байгууламжийг сайжруулах, өргөтгөх, шинэчлэх; 2.Бичигт хилийн боомтын барилга байгууламжийн угсралтын ажлыг үргэлжлүүлэх; 3.Гүйцэтгэгчтэй гэрээ цуцалж, тендер зарлах бэлтгэл ажил хангах; 4.Барилга угсралтын ажлын явцад хяналт хийх зөвлөх үйлчилгээний ажлыг үргэлжлүүлэх; 5.Өмнөх онд ирүүлсэн тендерийн материалыг үнэлж, сонгон шалгаруулалт хийж, худалдан авалт хийх; Зарлагдаагүй багцуудад <sup>1</sup> хамаарах тоног төхөөрөмж нийлүүлэх тендер зарлаж, худалдан авалт хийх	Нийт – 6 2025 онд – 6	76.6
3	Гадаад худалдааны цахим нэг цонхны техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх	Нийт – 5 2025 онд – 1	40.0
4	1.Төслийн хүрээнд зохион байгуулах уулзалт, ярилцлага, сургалт семинарын бэлтгэл ажил болон хэрэгжилтийг ханган ажиллах; 2.Төслийн бичиг баримтад тусгагдсан, төслийн хэрэгжилтэд зайлшгүй шаардлагатай зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах, ажлыг гүйцэтгүүлэх	Нийт – 4 2025 онд – 2	77.7
5	Төслийн менежментийг хөгжүүлэх, бүрдүүлэх	2025 онд - 15	94.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>Нийт 66 2025 онд-26</b>	<b>77.5</b>

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 3,442.0 мянган ам.долларын төсөвт өртөгтэй 7 төрлийн бараа нийлүүлэх худалдан авах ажиллагаа, 3,759.0 мянган ам.долларын төсөвт өртөгтэй 4 төрлийн зөвлөх үйлчилгээний ажлыг тусгаж батлуулсан байна. Үүнээс: хилийн боомтын ухаалаг гарц тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн материалыг tender.gov.mn цахим сайтад 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр байршуулж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр нээхэд, 5 компани тендерийн материал ирүүлснээс Үнэлгээний хорооны сонгон шалгаруулалтаар “Мэйжүрмэнт” ХХК-тай 3,608,118.1 мянган төгрөгийн “Хилийн боомтуудад ухаалаг гарц нийлүүлэх ” гэрээг байгуулж, санхүүжүүлсэн дүн 16.7 хувьтай байна. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бусад худалдан авалтыг хилийн боомтуудын бүтээн байгуулалтын ажилтай уялдуулж хойшлуулсан байна.

<sup>1</sup> 2025 оны 3 дугаар сарын 5-нд шинэчлэгдэн батлагдсан ХАА-ны төлөвлөгөөнд шинээр нэмэгдэж тусгагдсан багцуудын худалдан авалтын ажил 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдана.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК-ийн ахлах аудитор Л.Номин, аудиторын туслах С.Булганчимэг, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр төслөөс ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжаар 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлан суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 21,919,045.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 219,190.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч нэгж 2025 оны төсвийг зарцуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3,624,930.0 мянган төгрөгийн 13 орлогын мэдээлэл, 7,910,897.3 мянган төгрөгийн 16 зарлагын мэдээлэл болон худалдан авах ажиллагааны мэдээлэл тус бүрийг бүрэн байршуулж, ил тод мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төсөл, арга хэмжээний эдийн засгийн тооцоо буруу хийгдсэнээс барилгын ажил, зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг нэмэгдэх, төсөл хэрэгжүүлэгч нэгжээс гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүйгээс гэрээний хугацаа удаа дараа сунгагдах, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн ашиглаж байгаа тоног, төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусах, төсөл зогсох зэрэг эрсдэл үүсэхээр байгааг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй. Тухайлбал:

- Алтанбулаг болон Боршоо боомтуудаар нэвтэрч буй олон улсын тээврийн хэрэгслийн дугаарыг таниулах нэмэлт камер суурилуулах шаардлага бий болсон;
- Алтанбулаг боомтын барилга байгууламжийн өртгөтөл, шинэчлэлийн ажлын 2-р ээлжийн ажлын гүйцэтгэлийн явцад 1 болон 2 давхрын хучилт суулт өгч хүчитгэсэн дам нуруу байхгүйгээс нэмж 12,790,435.7 мянган төгрөгийн зардал гарахаар тогтоогдсон;
- Гадаад худалдаа цахим нэг цонхны техникийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг 2020-2021 онуудад боловсруулсан боловч дахин шинэчлэх шаардлага гарчээ.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.